

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

2024 оны 11 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Хяналтын журмаар гомдол гаргах тухай

Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 128/ШШ2024/0490 дугаар шүүхийн шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 221/МА2024/614 дүгээр Магадлалыг эс зөвшөөрч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.4 дэх хэсгийг үндэслэн дараах гомдлыг хяналтын журмаар гаргаж байна. Үүнд:

I. Шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах үндэслэл:

1. Татварын улсын байцаагч нарын үйлдсэн Нөхөн ногдуулалтын акт нь Захиргааны ерөнхий хуулийн 4.2.5. “зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх;”, Татварын ерөнхий хуулийн 5.1.2. “тодорхой байх;” 5.1.3. “шударга байх;” зарчмыг зөрчсөн. Өөрөөр хэлбэл татварын улсын байцаагч эхлээд хяналт шалгалтад хамрагдаж буй аж ахуйн нэгж бүрийн ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаа, орлого, зарлагын болон бусад бодит тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлох үйл ажиллагааг гүйцэтгээд Ашигт малтмалын тухай хуулийн 47.2.3-д “дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэн нөхөн татвар ногдуулах” уу, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 294 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох журам”-ын 2.2.6. “уул уурхайн бүтээгдэхүүний үнийг Ашигт малтмалын тухай хуулийн 47.14-т заасан эх үүсвэрийн дагуу эрх бүхий этгээдийн нийтэд зарласан үнийн мэдээлэл, ийм мэдээлэл байхгүй бол статистикийн үнийн мэдээлэл ашиглах” уу гэдгийг шийдэх ёстой байтал шууд журмын 2.2.6.уул уурхайн бүтээгдэхүүний үнийг Ашигт малтмалын тухай хуулийн 47.14-т заасан эх үүсвэрийн ашиглаж нөхөн ногдуулалтын акт тавьсан нь шийдвэр нь үндэслэлгүй болсон.
2. Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5. “зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх;” 4.2.8. “хууль ёсны итгэлийг хамгаалах” гэсэн зарчим нь Татварын ерөнхий хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.3.-д “татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, түүнийг хэрэгжүүлэх боломжийг хангах, тэдэнд итгэл үзүүлэх;” гэсэн зарчимтай харилцан хамааралтай салбар эрх зүйд хэрэглэгдэх ба манай тохиолдолд бидний зүгээс АМНАТ-ийг огт төлөөгүй биш төлсөн, гагцхүү бидний төлөлтийг Монголын татварын алба зөв байна хэмээн удаа дараа тайлан хүлээн авч байсныг анхаарч үзэх хэрэгтэй.

Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1. “Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана.” гэж заасны дагуу манай компанийн үйлдсэн татварын тайланг маш өндөр дүнтэй хаана байдаг нь эргэлзээтэй зарлаж буй үнэ нь бодит үнэн биш бирж гэх байгууллагын үнэнд таарахгүй байна гэж

удаа дараа буцаагаад байхаар бидний зүгээс дээр дурдсан хуулийн зохицуулалтын дагуу татварын тайлангаа татварын албанд цаасаар үйлдэн шуудангаар хүргүүлдэг байсан. Гэтэл Татварын алба биднийг огт тайлан гаргадаггүй, хүргүүлээгүй гэж үзэж байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

- 3. Татварын улсын байцаагч нар нь Ашигт малтмалын нөөц ашигласны албан татвар ногдуулахдаа татварыг бодитой, шударгаар ногдуулах зарчмыг зөрчсөн болохыг анхан болон давж заалдах шатны шүүхээс дүгнэж үзсэнгүй. Тухайлбал, татварын улсын байцаагч нар нь тооцоолол дээр алдаа гаргаж жоншны ачилт болгон дээр болон зарим үед дээж өгөх бүрт сар бүр жишиг үнэд өөрчлөлт орж байсныг харгалзан үзэхгүйгээр татвар ногдуулсан нь үндэслэлгүй юм.

Түүнчлэн манай компани нь жоншны нөөцийг ашиглаж олборлосон уул уурхайн компаниудаас худалдан авч зөвхөн экспортод гаргах худалдааны бизнес эрхэлсэн бөгөөд энэ тохиолдолд жонш олборлогч компаниуд нь АМНАТ-аа хуульд заасан үүргийнхээ дагуу төлсөн гэдэг тайлбарыг татварын улсын байцаагч нар шалгаж үзэхгүйгээр нөхөн ногдуулалтын акт ногдуулсан. Өөрөөр хэлбэл нэг төрлийн бүтээгдэхүүн дээр 2 удаа буюу татварыг давхардуулан ногдуулсан болохыг шүүхээс анхаарч үзэлгүйгээр шийдвэр гаргасанд гомдолтой байна.

II. Хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байх үндэслэл:

Татварын улсын байцаагч нар нь манай компанийн экспортод гаргасан жоншны бүтээгдэхүүний жин (тонн) бүхий гаалийн мэдүүлэг болон бэлэн бусаар дансаар шилжүүлсэн гүйлгээний хуулга, жонш худалдах гэрээ зэрэг санхүүгийн анхан шатны баримтуудыг бүрэн шалгаж тогтоосон атлаа бодит үнээр биш харин олон улсын жишиг үнэ гэх хийсвэр үнээр тооцож татвар ногдуулж байгаа нь хууль хэрэглээний хувьд илэрхий ноцтой зөрчилд тооцогдоно.

Манай Улс дэлхийн зах зээл рүү жоншийг шууд худалдах боломжгүй бөгөөд далайд гарцгүй зөвхөн 2 хөрш улсдаа экспортох боломжтой учраас олон улсын зах зээлийн өрсөлдөөнд оролцох, улмаар жишиг үнээр бүтээгдэхүүнээ борлуулах бодит боломж байхгүй гэдгийг татварын байгууллага сайн мэдэж байгаа. Мөн жонш нь биржийн бус бараа бүтээгдэхүүн тул олон улсын биржүүдээр арилжаалах боломжгүйн зэрэгцээ бүтээгдэхүүний овор хэмжээ ихтэйгээс шалтгаалж тээвэр логистикийн хүчин зүйлээс шууд шалтгаалдаг бүтээгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл уурхайн аман дээрх жоншны үнэ болон ачилт хийсэн, тээвэрлэж төмөр замын өртөө хүргэсэн, улсын хил хүртэл тээвэрлэгдсэн нэгж жоншны үнэ хүртэл харилцан адилгүй нэмүү өртөг, зардал шингэсэн үнэтэй байдаг.

Гэтэл татварын улсын байцаагч нар нь тухайн улсын орон нутгийн үнийг мэдээллэдэг, зөвхөн мэдээллийн шинжтэй албан бус цахим хуудас болох www.indmin.com гэх хаяг дээрээс БНХАУ-ын Тянь-жин боомт дээр FOB (Free On Board) үнэ буюу усан онгоцны тавцан дээрх үнээс тооцож татвар ногдуулж байгаа нь илтэд үндэслэлгүй юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хилээр экспортод гарсан жоншны бүтээгдэхүүн БНХАУ-ын нутаг дэвсгэр дээр хэдэн мянган километр тээвэрлэгдэж, ачилт буулгалтын үнэ, тээврийн үнэ, орон нутгийн болон улсын татвар хураамж тооцогдож улмаар далайн боомтоос дэлхийн өнцөг булан бүр лүү хамгийн хямд усан тээврээр зөөвөрлөгдөх боломжтой бүх үнэ, зардал, өртөг шингэсэн бүтээгдэхүүний үнээс тооцож Монгол Улсад татвар ногдуулж байгаа нь эрүүл ухаанаар ойлгох боломжгүй зүйл юм.

Өнөөдөр энэхүү дэлхийн зах зээлийн үнийг тогтоосон гэх www.indmin.com цахим хуудсанд хандахад www.fastmarket.com гэсэн албан бус мэдээллийн шинжтэй цахим хуудас болсон байгаа нь дэлхийн зах зээлийн үнийг тогтоодог мэдээллийн эх сурвалж биш гэдэг нь илэрхий харагддаг. Тухайлбал, жоншны үнийг өмнө Тянь-жиний боомт дээрх мэдээлэл тавигдсан бол одоо Мексикийн үнийг тавьсан байгаа нь албан бус эх сурвалж гэдгийг нь тодорхой харуулж байна.

Аливаа эрдэс баялаг нь шат дамжлаг бүрээр үнэ өсч, мөн эцсийн бүтээгдэхүүн болох хүртлээ өртөг зардал шингэж нэмүү өртөг үүсгэдэг тул анхны баяжмалын борлуулалтаас үйлдвэрийн дамжлагад шингэх үеийн үнээр тооцож татвар ногдуулах үндэслэлгүй юм.

Иймд Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 128/ШШ2024/0490 дугаар шүүхийн шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 221/МА2024/614 дүгээр Магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж өгнө үү.

Хавсралт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт 1 хуудас.



[Handwritten signature]

П.ХУРЦБИЛЭГТ